



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: НТАГ-2026/001/НА-СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: Я.Алтанцэцэг
Утас: 315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-
ийн захирал: А.Сарангэрэл
Утас: 99884842 Цахим хаяг: gereltekhburtgelaudit06@gmail.com

Улаанбаатар хот
2026 он



ҮНДСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ЦНИС, Г.Э.Г.Д.Х
ГОРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ
ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Ш.АРИУНТУЯА ТАНАА

14230 Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан
Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан
Хувийн бичигтэй тусгай зөвшөөрлийн үйлчилгээний байр
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 10000-00000

2026.02.25 № 158

Хугацаа: 01.02.2026 - 01.02.2026

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага нь давхардсан тоогоор нийт 9334 ажил олгогчоос авах авлагын эцсийн үлдэгдэлд 6 төрлийн арга хэмжээ авч ажилласан байна. Үүнээс 604 ажил олгогчид сануулах арга хэмжээ авч, 344 байгууллагад улсын байцаагчийн албан шаардлага өгч, 8047 ажил олгогчийн харилцах дансны зарлагын гүйлгээг хааж, 250 ажил олгогчтой гэрээ, график байгуулж, 83 ажил олгогчийг иргэний хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлж, 8 ажил олгогчийн шүүхийн шийдвэрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Нийгмийн даатгалын мэдээллийн системийг шинэчлэх, хөгжүүлэх ажлыг "Ай Ти Зон" ХХК нь Азийн хөгжлийн банкны төслөөр нэвтрүүлж үндсэн 16 систем, туслах 45 систем, 100 гаруй модуль бүхий нэгдсэн веб суурьтай нэг мэдээллийн сан бүхий Sicos системд шилжүүлсэн бөгөөд энэхүү программаас нийгмийн даатгалын сангийн ерөнхий журнал боловсруулагдаж гарахгүй байна.

1426950031

Бусад асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 4 хөтөлбөрийн 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, НДЕГ-аас жилийн эцэст 82.7 хувьтай гэж үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	102,979,174,139.52	119,793,068,789.11
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,716,946,898.11	17,226,263,821.70
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	15,716,946,898.11	17,226,263,821.70
31210	Төгрөг	15,716,946,898.11	17,226,263,821.70
31213	Арилжааны банк дахь харилцах	15,716,946,898.11	17,226,263,821.70
33	АВЛАГА	87,262,227,241.41	102,566,804,967.41
33300	Татаас, санхүүжилтийн авлага	20,089,924,277.13	20,101,533,472.13
33402	Татвар, НДШ-ын авлага	65,310,311,846.43	81,497,217,805.37
33500	Бусад авлага	1,861,991,117.85	968,053,689.91
33510	Байгууллагаас авах авлага	736,290,514.44	76,976,713.54
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,125,700,603.41	891,076,976.37
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	102,979,174,139.52	119,793,068,789.11
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,399,103,534.12	18,364,407,820.95
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,399,103,534.12	18,364,407,820.95
41300	Өглөг	4,270,010,393.38	12,133,824,147.75
41360	Бусад өглөг	4,270,010,393.38	12,133,824,147.75
41361	Байгууллагад төлөх өглөг	40,412,886.00	4,179,433.50
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	4,031,416,898.74	11,752,628,559.53
41366	Дансны өглөг	198,180,608.64	377,016,154.72
41400	Урьдчилж өрсөн орлого	4,129,093,140.74	6,230,583,673.20
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	4,129,093,140.74	6,230,583,673.20
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	94,580,070,605.40	101,428,660,968.16
51200	Хуримтлагдсан үр дүн	94,580,070,605.40	101,428,660,968.16
51210	Өмнөх үеийн үр дүн	115,436,405,570.18	95,516,388,147.59
51220	Тайлант үеийн үр дүн	20,856,334,964.78	5,912,272,820.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	102,979,174,139.52	119,793,068,789.11
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	102,979,174,139.52	119,793,068,789.11

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	960,888,710,208.24	1,132,079,495,230.66
11	ТАТВАРЫН ОРЛОГО	419,512,509,631.01	475,296,650,575.97
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	419,512,509,631.01	475,296,650,575.97
1122	Тэтгэврийн даатгалын шимтгэл	350,353,969,257.72	396,929,389,710.97
112001	Бусад тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	350,353,969,257.72	396,929,389,710.97
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого	36,832,736,268.56	42,281,751,920.42
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэлийн орлого	19,706,821,636.51	21,704,877,489.23
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого	12,618,982,468.22	14,380,631,455.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	814,108,326.23	656,782,844,654.69
120	Нийтлэг татварын бус орлого	814,108,326.23	794,395,624.69
1201	Хуугийн орлого	311,862,753.72	289,138,600.75
120002	Бусад хуугийн орлого	311,862,753.72	289,138,600.75
120003	Торгуулийн орлого	8,298,300.00	12,927,000.00
120009	Бусад орлого	493,947,272.51	492,330,023.94
122	Тусламжийн орлого	-	655,988,449,030.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	655,988,449,030.00
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	222,518,970,034.00
122152	НДС-д УТ-с олгох татаасын орлого (УТ-НДС)	-	222,518,970,034.00

Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

122004	НДС-ын санхүүжилтийн шилжүүлгийн орлого\	-	433,469,478,996.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	540,562,092,251.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	178,370,993,851.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	178,370,993,851.00	-
1330	Төсвийн захирагчдаас	362,191,098,400.00	-
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	362,191,098,400.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	981,745,045,173.02	1,126,167,222,410.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	981,745,045,173.02	1,126,167,222,410.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,772,660.00	33,330,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,772,660.00	33,330,350.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,905,000.00	3,960,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	28,867,660.00	29,370,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	981,712,272,513.02	1,126,133,892,060.09
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	459,567,963,897.67
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	459,567,963,897.67
213104	НДС-н орлогын төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	459,567,963,897.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	573,920,089,640.07	666,565,928,162.42
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	573,920,089,640.07	666,565,928,162.42
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	407,792,182,872.95	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	407,792,182,872.95	-
III	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-20,856,334,964.78	5,912,272,820.57
VI	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИИТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	-20,856,334,964.78	5,912,272,820.57

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,026,391,334,771.70	1,210,915,543,393.57
11	ТАТВАРЫН ОРЛОГО	487,163,025,106.94	460,790,051,744.34
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	487,163,025,106.94	460,790,051,744.34
1122	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	342,291,386,177.08	384,889,870,604.20
112001	Бусад тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	342,291,386,177.08	384,889,870,604.20
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого	36,073,360,420.44	40,847,902,707.27
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэлийн орлого	20,511,814,905.41	21,239,024,588.27
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого	12,974,132,955.62	13,813,253,844.60
1121	Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого	75,312,330,648.39	-
112005	Бусад эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого	75,312,330,648.39	-
12	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	805,083,764.76	750,125,491,649.23
120	Нийтлэг татварын бус орлого	805,083,764.76	94,111,947,753.23
1201	Хүүгийн орлого	312,978,230.12	289,543,284.44
120002	Бусад хүүгийн орлого	312,978,230.12	289,543,284.44
120009	Бусад орлого	492,105,534.64	93,822,404,468.79
122	Тусламжийн орлого	-	656,013,543,896.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	656,013,543,896.00
12215	Төсөв хоорондын хандив тусламж	-	222,544,064,900.00
122152	НДС-д УТ-с олгох татаасын орлого (УТ-НДС)	-	222,544,064,900.00
122004	НДС-ын санхүүжилтийн шилжүүлгийн орлого	-	433,469,478,996.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	538,423,225,900.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	176,232,127,500.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	176,232,127,500.00	-
1330	Төсвийн захирагчдаас	362,191,098,400.00	-
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	362,191,098,400.00	-
II	НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,058,810,567,688.31	1,209,406,226,469.98

Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,058,810,567,688.31	1,209,406,226,469.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	750,824,355.36	497,240,340.79
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,772,660.00	33,330,360.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,905,000.00	3,960,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	28,867,660.00	29,370,350.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	718,051,695.36	463,909,990.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	718,051,695.36	463,909,990.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,058,059,743,332.95	1,208,908,986,129.19
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	552,059,639,473.42
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	552,059,639,473.42
213104	НДС-ын орлогын төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\)	-	552,059,639,473.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	570,278,344,936.55	656,849,346,655.77
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	570,278,344,936.55	656,849,346,655.77
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	487,781,398,396.40	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	487,781,398,396.40	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-32,419,232,916.61	1,509,316,923.59
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-32,419,232,916.61	1,509,316,923.59
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	48,136,179,814.72	15,716,946,898.11
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,716,946,898.11	17,226,263,821.70

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	125,120,032,291.06	125,120,032,291.06
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-9,683,626,720.88	-9,683,626,720.88
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	115,436,405,570.18	115,436,405,570.18
9	Тайлант үеийн үр дүн	-	-	-20,856,334,964.78	-20,856,334,964.78
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	94,580,070,605.40	94,580,070,605.40
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	94,580,070,605.40	94,580,070,605.40
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	936,317,542.19	936,317,542.19
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	95,516,388,147.59	95,516,388,147.59
19	Тайлант үеийн үр дүн	-	-	5,912,272,820.57	5,912,272,820.57
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	101,428,660,968.16	101,428,660,968.16

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	НИИТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	758,901,530,200.00	684,857,581,508.22	74,043,948,691.78	90.2
11	Татварын орлого	536,357,465,300.00	462,313,516,608.22	74,043,948,691.78	86.2
112	Нийгмийн даатгалын орлого	536,357,465,300.00	462,313,516,608.22	74,043,948,691.78	86.2
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	459,350,495,300.00	386,141,967,095.70	73,208,528,204.30	84.1
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	41,059,707,900.00	40,951,300,834.14	108,407,065.86	99.7
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	19,978,907,200.00	21,252,910,419.31	-1,274,003,219.31	106.4
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	15,968,354,900.00	13,967,338,259.07	2,001,016,640.93	87.4
12	Татварын бус орлого	222,544,064,900.00	222,544,064,900.00	-	100.0
122	Тусламжийн орлого	222,544,064,900.00	222,544,064,900.00	-	100.0
122001	Хандив тусламж /дотроод/	222,544,064,900.00	222,544,064,900.00	-	100.0
II	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	657,034,174,500.00	656,882,677,005.77	151,497,494.23	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	657,034,174,500.00	656,882,677,005.77	151,497,494.23	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,698,100.00	33,330,350.00	29,367,750.00	53.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	62,698,100.00	33,330,350.00	29,367,750.00	53.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,394,700.00	3,960,000.00	10,434,700.00	27.5
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	48,303,400.00	29,370,350.00	18,933,050.00	60.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	656,971,476,400.00	656,849,346,655.77	122,129,744.23	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	656,971,476,400.00	656,849,346,655.77	122,129,744.23	99.9
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	656,971,476,400.00	656,849,346,655.77	122,129,744.23	99.9
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИИТ ТЭНЦЭЛ	101,867,355,700.00	27,974,904,502.45	73,892,451,197.55	27.4
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-101,867,355,700.00	-27,974,904,502.45	73,892,451,197.55	27.4
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-101,867,355,700.00	-27,974,904,502.45	73,892,451,197.55	27.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	15,716,946,898.11	15,716,946,898.11	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	17,226,263,821.70	17,226,263,821.70	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг Нийгмийн даатгалын тухай хуулийн 4¹ дүгээр зүйлийн 4^{1.1.6}-д "Нийгмийн даатгалын байгууллага" гэж нийгмийн даатгалын сан бүрдүүлж, даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх зэрэг үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд" гэж тодорхойлсон.

Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын сан "Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх, нийгмийн даатгалын үйлчилгээ хүргэж, 2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий даатгагч болно" гэсэн эрхэм зорилгын дор 2025 онд "Нийгмийн даатгалын байгууллага нь өсөн дэвжих эрмэлзэлтэй, мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцөд түшиглэсэн үйл ажиллагаагаа цаг үргэлжид сайжруулан, түншлэл хамтын ажиллагааг дэмжин харилцан үр ашигтай хамтран ажиллаж, сайн засаглалыг хэрэгжүүлэн хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай үйлчилгээг даатгуулагчдад хүргэнэ" гэсэн үндсэн зорилгыг дэвшүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- МУЗГ-ын 2025 оны 65 дугаар тушаалаар "Даатгуулагчийн шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход 2026 онд хэрэглэх итгэлцүүр" шинэчлэн батлагдсан;
- НДҮЗ-ийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор "Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцох журам" шинэчлэн батлагдсан;
- НДҮЗ-ийн 2025 оны 08 дугаар тогтоолоор "Мөнгөн хадгаламжийн 2025 оны хүүгийн доод хэмжээ" шинэчлэн батлагдсан;
- НДҮЗ-ийн 2025 оны 10 дугаар тогтоолоор "Нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээ" шинэчлэн батлагдсан;
- НДҮЗ-ийн 2025 оны 11 дүгээр тогтоолоор "Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээ" шинэчлэн батлагдсан;
- НДЕГ-ын 2025 оны А/204 дүгээр тушаалаар "Маягтын загвар" шинэчлэн батлагдсан;
- НДЕГ-ын даргын 2025 оны А/281 дүгээр тушаалаар "Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэх тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, даатгуулагч, ажил олгогч, тэтгэвэр авагчийн маягтын жагсаалт"-д нэмэлт өөрчлөлт оруулсан;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтог хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын сан нь НДЕГ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/243 дугаар тушаалаар баталсан НБББББ-ийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайланг 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүр өмнөх оноос 16,813,894.7 мянган төгрөгөөр буюу 14.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	15,716,946.8	17,226,263.8	1,509,317.0
Авлага	87,262,227.2	102,566,804.9	15,304,577.7
Нийт хөрөнгийн дүн	102,979,174.2	119,793,068.8	16,813,894.7
Өр төлбөр	4,270,010.4	12,133,824.2	7,863,813.8
Урьдчилж орсон орлого	4,129,093.2	6,230,583.7	2,101,490.5
Хуримтлагдсан үр дүн	94,580,070.6	101,428,661.0	6,848,590.4
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн/	102,979,174.2	119,793,068.8	16,813,894.7

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, өр төлбөр, урьдчилж орсон орлого данс байна.

Авлагын дансны үлдэгдэл 102,566,804.9 мянган төгрөг болж, 15,304,577.7 мянган төгрөгөөр өссөн нь ажил олгогч байгууллагуудаас авах нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 16,186,905.9 мянга, улсын төсвөөс авах татаас санхүүжилтийн

авлага 11,609.2 мянга, хувь хүмүүсээс авах авлага 234,623.6 мянган төгрөгөөр тус тус өссөн, байгууллагаас авах авлага 659,313.8 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэлд ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагуудаас авах НДШ-ийн 81,497,217.8 мянган төгрөгийн, тэтгэвэр, тэтгэмж авагч нартай холбоотой зөрчилд улсын байцаагчаас тогтоосон акт, алдангийн 968,053.6 мянган төгрөг, Засгийн газрын 2022 оны тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох, бүртгэх, тайлагнах, хяналт тавих журам"-тай холбоотой улсын төсвөөс авах татаас санхүүжилтийн 20,101,533.4 мянган төгрөг, нийт 102,566,804.9 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага дансанд нийт 4483 ажил олгогчоос авах 1 жилийн насжилттай 47,624,010.9 мянган төгрөг, 1071 ажил олгогчоос авах 2-3 жилийн насжилттай 21,493,786.2 мянган төгрөг, 4-5 насжилттай 593 ажил олгогчоос авах 13,890,295.0 мянган төгрөг, 5-аас дээш жилийн 1034 ажил олгогчоос авах 13,540,093.2 мянган төгрөг, нийт 7181 ажил олгогчоос авах 96,548,185.5 мянган төгрөгийн авлагатай байна.

Байгууллага нь давхардсан тоогоор нийт 9334 ажил олгогчоос авах авлагын эцсийн үлдэгдэлд 6 төрлийн 9334 арга хэмжээ авч ажилласан байна. Үүнээс 604 ажил олгогчид сануулах арга хэмжээ авч, 344 байгууллагад улсын байцаагчийн албан шаардлага өгч, 8047 ажил олгогчийн харилцах дансны зарлагын гүйлгээг хааж, 250 ажил олгогчтой гэрээ, график байгуулж, 83 ажил олгогчийг иргэний хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлж, 8 ажил олгогчийн шүүхийн шийдвэрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлэн ажилласан байна.

Өглөг дансны үлдэгдэл 12,133,824.2 мянган төгрөг болж, 7,863,813.8 мянган төгрөгөөр өссөн нь ажилгүйдлийн даатгалын сангаас даатгуулагчдад олгох өглөг өссөнөөс шалтгаалжээ.

Өглөгийн дансны эцсийн үлдэгдэлд ажилгүйдлийн даатгалын сангаас 2633 даатгуулагчдад олгох ажилгүйдлийн тэтгэмжийн 8,649,293.2 мянган төгрөг, тэтгэвэр тэтгэмжийн сангаас тэтгэвэр авагч нарт олгох 3,103,335.6 мянган төгрөг, байгууллага, хувь хүмүүст буцаан олгох шимтгэлийн 381,195.6 мянган төгрөг, нийт 12,133,824.2 мянган төгрөгийн өглөг бүртгэлтэй байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 6,230,583.7 мянган төгрөг болж, 2,101,490.5 мянган төгрөгөөр өссөн нь ажил олгогч болон даатгуулагчийн урьдчилж төлсөн нийгмийн даатгалын шимтгэл төлөлт өссөнөөс шалтгаалсан байна.

Урьдчилж орсон орлого дансны эцсийн үлдэгдэлд 2962 ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагын илүү төлсөн шимтгэлийн 2,490,381.2 мянган төгрөг, сайн дурын даатгуулагч, малчин, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ харж буй эцэг, эхийн урьдчилж төлсөн 3,740,202.4 мянган төгрөг, нийт 6,230,583.6 мянган төгрөгийн өглөг бүртгэлтэй байна.

Урьдчилж орсон орлого дансны эцсийн үлдэгдэлд 2962 ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагын илүү төлсөн шимтгэлийн 2,490,381.2 мянга төгрөг, 1 жилийн насжилттай 1515 ажил олгогчид өгөх 2,333,779.0 мянган төгрөг, 2-3 жилийн насжилттай 143 ажил олгогчид өгөх 38,220.9 мянган төгрөг, 4-5 жилийн насжилттай 59 ажил олгогчид өгөх 13,586.0 мянган төгрөг, 5-аас дээш жилийн насжилттай 1245

ажил олгогчид өгөх 104,795.1 мянган төгрөг, нийт 2962 ажил олгогчид өгөх 2,490,381.2 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 171,190,785.0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант онд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 144,422,177.2 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардал байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 127,679,423.9 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 655,671,059.1 мянган төгрөг, нийт зарлагыг 783,350,482.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 139,294,393.2 мянган төгрөгөөр бууруулж 644,056,089.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжилтийг 90,266,641.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 217,946,064.9 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлогыг 117,587,555.8 мянган төгрөгөөр бууруулж, 538,083,503.3 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвийн санхүүжилтийг 4,598,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 222,544,064.9 мянган төгрөгөөр тодотгож, үйл ажиллагааны орлогыг 1,726,038.0 төгрөгөөр бууруулж, 536,357,465.3 мянган төгрөгөөр тодотгож баталсан байна. Нийт зардлыг 12,978,084.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 657,034,174.6 мянган төгрөгөөр тодотгож, баталсан байна.

Тайлант 2025 онд НДЕГ-ын даргын 2023 оны "Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1-т заасны дагуу тус сангаас 552,059,639.4 мянган төгрөгийг НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд төвлөрүүлж, мөн журмын 4 дүгээр зүйлийн 4.1-д заасны дагуу НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах данснаас тус санд төсвийн хуваарийг үндэслэн улсын төсвийн санхүүжилт 222,544,064.9 мянган төгрөг, санхүүжилтийн орлого 433,469,478.9 мянган төгрөг, нийт 656,013,543.8 мянган төгрөгийг хуваарилж, санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 656,882,677.0 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь тэтгэвэр, ҮОМШӨ-ний сангийн 151,497.51 мянган төгрөгийн олголтыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
2	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	656,971,476.4	656,849,346.6	122,129.8	99.9
2.1	Тэтгэврийн даатгалын шимтгэл	592,007,959.3	591,690,130.1	317,829.2	99.9
2.2	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	34,970,260.3	35,023,153.0	-52,892.7	100.1
2.3	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	4,678,395.3	3,978,548.8	699,846.5	85.0
2.4	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	25,314,861.5	26,190,845.1	-875,983.6	103.5
3	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	62,698.1	33,330.4	29,367.7	53.2
3.1	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,394.7	3,960.00	10,434.7	53.2
3.2	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	48,303.4	29,370.4	18,933.0	60.8
Нийт дүн		657,034,174.5	656,882,677.1	151,497.49	99.8

Төсвийн гүйцэтгэл

Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын сан нь 2025 онд баталсан төлөвлөгөөгөөр 536,357,465.3 мянган төгрөг төвлөрүүлэхээс 462,313,516.6 мянган төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөнөөс 74,043,948.7 мянган төгрөгөөр буюу 13.8 хувиар дутуу биелүүлсэн байна.

Хүснэгт 3. Нийгмийн даатгалын сангийн төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэврийн сан	459,350,495.3	3861,41,967.1	73,208,528.2	84.1
Тэтгэмжийн сан	41,059,707.9	40,951,300.8	108,407.1	99.8
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн даатгалын сан	19,978,907.2	21,252,910.4	-1,274,003.2	106.4
Ажилгүйдлийн даатгалын сан	15,968,354.9	13,967,338.2	2,001,016.6	87.4
Нийт дүн	536,357,465.3	462,313,516.6	74,043,948.6	86.2

Хүснэгт 4. Улсын төсвийн санхүүжилтийн орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэврийн даатгалын сан	222,118,889.7	222,118,889.7	-	100.0
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн даатгалын сан	425,175.2	425,175.2	-	100.0
Нийт дүн	222,544,064.9	222,544,064.9	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн

тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд тайлант онд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус санд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Засгийн газрын төвлөрсөн сангийн хувьд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайлан хамааралгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын сан нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн сангийн үйл ажиллагааг сайжруулахаар ажил олгогчоос авах авлагыг барагдуулах дараагийн шатны арга хэмжээ авах, даатгуулагчаас авах авлагыг барагдуулах, он дамжсан илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох арга хэмжээ авах, Нийгмийн даатгалын багц хуулийг ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-эрдэнэ, туслах аудитор Э.Алтангэрэл, Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, дараагийн шатны чанарын хяналтыг Нийслэл дэх Төрийн аудитын газрын аудитын менежер Я.Алтанцэцэг, ахлах менежер Х.Түвшинбаяр, газрын дарга, Тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын сан нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/59 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын дансыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны нийт зардлын 981,745,045.2 мянган мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9,817,450.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн захирагч нь хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалтуудыг мөрдөж, хэмнэлтийн горимыг баримтлан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 72 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын сан нь 2025 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нийт 2,914,609,998.2 мянган төгрөгийн 12644 мэдээллийг ил тод байршуулахаас 2,914,609,998.2 мянган төгрөгийн 12644 мэдээллийг ил тод мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг аудитад хамруулж 89,394,706.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж 85,481,962.9 мянган төгрөгийн 2 алдааг залруулах, зөрчлийг арилгах 3,912,743.4 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар давтан үнэлэхэд 89,394,706.2 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 3,896,203.1 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгаж, аудитын шийдвэрийг хэрэгжүүлсэн байна. Нийт 16,540.3 мянган төгрөгийн 1 зөрчлөөс хэрэгжээгүй 16,349.8 мянган төгрөгийн зөрчлийг асуудлын бүртгэлд тусгалаа.

4.5.2 Өмнөх шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 482,860.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 3 зөвлөмж өгсөн байна.

Нийт илрүүлсэн 482,860.1 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт-1: Нийт 35 идэвхитэй ажил олгогч байгууллагаас авах нийгмийн даатгалын шимтгэлийн 1 жилийн насжилттай, нийт 412,995.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах дараагийн шатны арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...", мөн хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.5-д "Нийгмийн даатгалын байгууллага энэ журмын 6.1-д заасан ажил олгогчийн шимтгэлийн өрийг 6.4-т заасан хугацаанаас хойш төлөгдөөгүй хугацаагаар нь дараах байдлаар ангилна", 6.6-д "Нийгмийн даатгалын шимтгэлийг өрийг барагдуулах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Идэвхитэй ажил олгогчоос авах авлагыг барагдуулах дараагийн шатны арга хэмжээ авч хэрэгжүүлэх зөвлөмж өгөв.

Илрүүлэлт-2: Нийт 40 идэвхигүй ажил олгогч байгууллагын илүү төлсөн шимтгэлийн 2-10 жилийн насжилттай, нийт 53,514.8 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг буцаан олгох арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...", мөн хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Идэвхигүй ажил олгогчийн он дамжсан, илүү төлсөн шимтгэлийн өглөгийг буцаан олгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх зөвлөмж өгөв.

Илрүүлэлт-3: Жирэмсэн амаржсан 39 эхчүүдэд илүү шилжүүлсэн 15,328.8 мянган төгрөг, хөдөлмөрийн чадвараа алдсан 2 иргэнд илүү шилжүүлсэн 1,021.1 мянган төгрөг, нийт 16,349.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...", мөн хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгий тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Илүү шилжүүлсэн шалтгааныг тодорхойлж, авлагыг барагдуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дугаа сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Идэвхитэй ажил олгогчийн авлагыг барагдуулах дараагийн шатны арга хэмжээ аваагүй	1	412,995.4	-	-	-	-	1	412,995.4	-	-	-	-
Идэвхигүй ажил олгогчийн он дамжсан, илүү төлсөн шимтгэлийн өглөгийг барагдуулах арга хэмжээ аваагүй	1	53,514.8	-	-	-	-	1	53,514.8	-	-	-	-
Жирэмсэн амаржсан болон хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч нарт илүү шилжүүлсэн авлагыг барагдуулаагүй	1	16,349.9	-	-	-	-	1	16,349.9	-	-	-	-
Дүн	3	482,860.1	-	-	-	-	3	482,860.1	-	-	-	-